



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



INVEST IN MONGOLIA

2021 оны 2 дугаар сар

INVEST IN MONGOLIA

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРААС ЭРХЛЭН ГАРГАВ
ДУГААР 01

АГУУЛГА

**ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТОЙМ**

ГАДААД ХУДАЛДААНЫ ТОЙМ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

**ТА МАНАЙ ХӨРӨНГӨ
ОРУУЛАГЧ**

**2021 ОНЫ ЭДИЙН
ЗАСГИЙН ЧИГ ТӨЛӨВ**

www.investmongolia.gov.mn



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



ХАНДЖАВ
БАТЖАРГАЛ

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА



БАЯСГАЛАНТ
БУЛГАНЧИМЭГ

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДЭД
ДАРГА



БААСАНДАВАА
ДӨЛГӨӨН

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДЭД
ДАРГА

ЭРХЭМ УНШИГЧ ТАНД ЭНЭ ӨДРИЙН МЭНД ХҮРГЭЭ

Үндэсний хөгжлийн газар нь 2021 онд хөрөнгө оруулалтын орчны цогц шинэчлэлийг эхлүүлэхээр зорин ажиллаж буй бөгөөд энэхүү үйл ажиллагааны хүрээнд хөрөнгө оруулагчдын тоо бүртгэлийг бусад төрийн байгууллагуудтай хамтран шинэчлэх, цар тахлын үед зориулан хөрөнгө оруулагчдад хүргэх үйлчилгээг цахимжуулах, Инвест Монголиа сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, улмаар хууль эрхзүйн орчныг сайжруулахаар төлөвлөж байна. Энэ санаачилгын түүчээ болон сар бүр хөрөнгө оруулагч танд хэрэгтэй мэдээллийг тоймлон хүргэх цахим товхимолыг монгол, англи хэлээр хүргэж буйг хүлээн авна уу. Энэхүү товхимолтой холбоотой санал хүсэлтийг манай газрын info@nda.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

ТА БҮХНИЙГ ХҮНДЭТГЭСЭН
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР

www.investmongolia.gov.mn

the **SAVE** **MAZAALAI**

САЙН БАЙЦГААНА УУ?

Та бүхэндээ 2 дугаар сарын мэдээ болон шинэчлэлтүүдийн талаар мэдээлэл хүргэх аяллаа эхлүүлэхээсээ өмнө өөрийн тухай баримтуудыг сонирхуулъя

БАЙРШИЛ:

МОНГОЛ УЛС

ТОО ТОЛГОЙ:

60

НӨХЦӨЛ БАЙДАЛ:


Жил дараалсан ган гачиг, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас мазаалайн иддэг ургамлын гарц эрс багасаж, булаг, шанд ширгэж усны эх булаг хомсдож буй нь түүний популяцийн тогтвортой байршил, идээшил нутаг хумигдах шалтгаан болж байна.



Gobi Bear Foundation / Говийн Мазаалай Хамгаалах сан

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТОЙМ

2020 ОНЫ I-III УЛИРЛААР МОНГОЛ УЛСАД ОРСОН ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ / САЛБАРААР /




• **2020 оны** гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс **6%-иар** буюу **877 сая** ам.доллараар буурч **12,870 сая** ам.доллар болов.


Үүнд экспорт **1%-иар** буюу **43 сая** ам.доллараар, импорт **14%-иар** буюу **834 сая** ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв.

Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс **790 сая** ам.доллараар өсөж **2,282 сая** ам.долларын ашигтай гарлаа.

2020 оны I-III улирлаар Монгол Улсад бүртгэгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тоо



2020 оны I-III улирлаар Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ





ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН ЭРГЭН ТОЙРОНД

Оюутолгойн “Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-г 2015 онд баталж байхдаа УИХ, Засгийн газар далд уурхайг 2021 оны нэгдүгээр сард үйл ажиллагаагаа эхлүүлнэ гэсэн ойлголт, хүлээлттэй байсан.

Гэвч энэ хугацаа 2022 оны 10 дугаар сар хүртэл хойшилсон бөгөөд Оюутолгой төслийн ТЭЗҮ-ийн шинэчилсэн тодотголын санхүүгийн тооцооллоос харахад төслийн хөрөнгө оруулалтын зардал анх төлөвлөснөөсөө 1.4 тэрбум ам.доллараар нэмэгдсэнээс үүдэн далд уурхайн эдийн засгийн өгөөж буурах асуудал үүсээд байгаа юм.

Уг хөрөнгө оруулалтын зардал өсөх тусам Монгол Улсын ногдол ашиг авах хугацаа хойшилдог. Тиймээс Монгол Улсын Засгийн газраас Оюутолгой төслийн хөрөнгө оруулагч талтай яриа хэлэлцээр хийж, хөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг 2019 оны 12 дугаар сард байгуулан ажиллаж байна.

Энэхүү ажлын хэсгийн төлөөл болон “Рио Тинто” компанийн шинээр томилогдсон гүйцэтгэх захирал Якоб Стаусхолм нар 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр цахим уулзалт зохион байгуулж, үүсээд буй шаардлага, нөхцөл байдлын талаар ярилцсан. Монгол Улсын Засгийн газрын зүгээс менежментийн үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэлтэй илүү уялдуулах, зээлийг хүүг бууруулах гэсэн шаардлагыг тавьсан.

Мөн менежментийн үйлчилгээ үзүүлж байгаа багийн ажлын үр дүнг сайжруулах, зардлын хэтрэлийг багасгах тал дээр илүү үр дүн гаргаж ажиллах боломжийг судлах саналуудыг хүргүүлсэн.

Уг хэлэлцээрийн мөрөөр эхний байдлаар хөрөнгө оруулалтын зардлын хэтрэл үүссэн шалтгааныг тогтоохоор хөндлөнгийн дүгнэлт гаргуулах чиглэлд ажиллаад эхэлсэн бөгөөд хариуг хүлээж байна.

Далдуурхай ашиглалтад орсноор олборлолтын хэмжээгээр дэлхийд дөрөвдүгээрт бичигдэнэ гэсэн хүлээлт бий.

Дэлхийн хэмжээний ийм уурхай Монгол Улсад үйл ажиллагаа явуулна гэдэг манай улсад ашигтай. Тиймээс Засгийн газар төслийн хэрэгжилтийг дэмжиж ажиллаж байгаа. Гэхдээ мэдээж үр ашгийн тал дээр үнэхээр өгөөжгүй бол энэ чигээр нь цааш явуулахад хэцүү учраас гэрээг сайжруулах тал дээр анхаарал хандуулан ажиллаж байна.

Хөрөнгө оруулагчдын зүгээс мөн энэ асуудал дээр хамтарч ажиллахаа илэрхийлсэн. Тиймээс хоёр талын яриа хэлэлцээр үргэлжилж байгаа бөгөөд асуудал нааштай шийдэгдэнэ гэж хоёр тал үзэж байна.



ГАДААД ХУДАЛДААНЫ ТОЙМ

АЗИ, НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улс нь 2020 оны 11 дүгээр сард “Ази, Номхон далайн орнуудын худалдааны хэлэлцээр”-т 7 дахь албан ёсны гишүүн орноор нэгдэн орж, хэлэлцээрийг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн байна.

Уг хэлэлцээр нь хөгжиж буй гишүүн орнуудын хоорондын худалдааг өргөжүүлж, тэдгээрийн эдийн засгийг хөхиүлэн дэмжих, худалдааг харилцан либералчлах, харилцан ашигтай хамтын ажиллагааг өрнүүлэх, гишүүн орнууд хоорондын худалдаан дахь тариф, тарифын бус болон худалдаатай холбоотой бусад саад тотгорыг бууруулах зорилготой юм.

Монгол Улс хэлэлцээрт нэгдэн орсноор үндэсний аж ахуйн нэгжүүд 2.9 тэрбум гаруй хэрэглэгчтэй, эдийн засгийн хурдацтай өсөлттэй АНДХХ-ийн 6 гишүүн улс руу нийтдээ 10,000 гаруй нэр төрлийн бараанд 5-100 хувийн татварын хөнгөлөлт эдлэх боломж нээгдэхийн зэрэгцээ дэлхийн болон бүс нутгийн нийлүүлэлтийн гинжин хэлхээнд холбогдох, хөрөнгө оруулалт татахад илүү таатай нөхцөл бүрдэх юм.

ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улс нь 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-т нэгдэн орсон 99 дэх улс болсон.

Хөгжиж буй, далайд гарцгүй орны хувьд Монгол Улс тус хэлэлцээрийг бүрэн хэрэгжүүлснээр худалдааны өртөг болон дамжин өнгөрүүлэх тээврийн зардлыг бууруулах, бараа импортолж, экспортлох үйл ажиллагаанд зарцуулагдаж буй хугацааг багасгах, хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах бүрэн боломжтой юм.

Уг хэлэлцээрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, салбар дундын зохицуулалт хийх чиг үүрэг бүхий Гадаад харилцааны сайдаар ахлуулсан “Үндэсний хороо”-г 2017 онд байгуулсан.



ЗАСГИЙН ГАЗРЫН БОДЛОГО

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЖ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ЗТ АРГА ХЭМЖЭЭ

ТҮРГЭВЧИЛСЭН

- Гадаадын хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээг нэг дор төвлөрүүлж, үйлчилгээний шийдвэрлэх хугацааг багасгах, хүндрэлийг арилгах, илүү таатай нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд Үндэсний хөгжлийн газраас олгодог “Хөрөнгө оруулагчийн тодорхойлолт”-ыг www.invest-assist.gov.mn цахим хаягаар олгож эхэлсэн. Ингэснээр Ковид-19 цар тахлын үед хөрөнгө оруулагчид болон төрийн албан хаагчдад цахимаар ажиллах, зардал, цаг хугацаа хэмнэх боломжийг бүрдүүлж байна.
- Монгол Улсын төрийн бүх үйлчилгээг цахимжуулах, цахим засаглалыг хөгжүүлэх зорилгоор E-MONGOLIA төслийн хэрэгжүүлж эхэлсэн. Ковид-19 цар тахлын үед иргэд www.e-mongolia.mn веб портал болон “E-Mongolia” гар утасны аппликейшн ашиглан аль нэг төрийн байгууллагыг зорьж очилгүйгээр өөрт хэрэгтэй төрийн үйлчилгээг гэрээсээ эсвэл ажил дээрээсээ ямар ч цаг үед авч болох боломжийг олгож байна. Одоогийн байдлаар харилцан ялгаатай чиг үүрэг бүхий төрийн 23 байгууллагын 181 үйлчилгээг нэвтрүүлж цахимаар авах боломжтой.

ТӨВЛӨРСӨН

- Иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор 18 хүртэлх насны хүүхэд бүрт сар бүр 100 мянган төгрөг олгож байна.
- Төрөөс хэрэгжүүлж байгаа ипотекийн хөнгөлөлттэй зээлийг 2021 оны 7 дугаар сарын 1-ны өдөр хүртэл үндсэн болон хүүгийн төлбөрийг зээлдэгчийн хүсэлтэд үндэслэн хойшлуулах, ингэхдээ үлдэгдэл төлбөрийн хэмжээг нэмэхгүйгээр зээлийн гэрээний хугацааг сунгах зохицуулалтын арга хэмжээ авч байна.
- Ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүн экспортолдог аж ахуйн нэгжийг халдвар хамгааллын онцгой дэглэмд шилжүүлж нийт ажилчдыг халдварт өвчнөөс хамгаалж, аюулгүй нөхцөл байдал бүрдүүлнэ.
- Ашигт малтмал, газрын тосны экспортыг хэвийн явуулах зорилгоор хилийн боомтуудыг халдвар хамгааллын онцгой дэглэмд бүрэн хүчин чадлаар ажиллуулж байна.
- 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл зарим аж ахуйн нэгжүүдийн цахилгаан, дулаан, хогны мөнгийг төр хариуцаж байна.
- Бүх айр өрхийн цахилгааны төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл тэглэсэн.
- Нэг шуудай шахмал түлшний үнийг 75 хувь хүртэл бууруулсан.

ТӨЛӨВЛӨГӨӨТ

- Гадаадад буй иргэдээ мэргэжлийн байгууллагын зөвлөгөөнд үндэслэн үе шаттай татан авчрах ажлын эрчимжүүлнэ. 2 дугаар сард 4 удаагийн тусгай үүргийн нислэг хийхээр төлөвлөөд байна.
- Хүн амаа Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрсөн вакцинд үе шаттайгаар хамруулах ажлыг Засгийн газрынхаа эхний 100 хоногт эхлүүлнэ. Энэтхэгийн Засгийн газраас Монгол Улсад Ковид-19 цар тахлын эсрэг вакцин нийлүүлэхээр шийдвэрлэж, 2020 оны 1 дүгээр сарын 19-ний өдрөөс 150 монгол эмчийг цахим сургалтад хамруулж эхлээд байна. Энэтхэгт Covishield болон Covaxin гэх 2 вакцин 1 дүгээр сарын 3-ны өдөр батлагдсан бөгөөд Covishield нь Энэтхэгийн Пуна хотод байрладаг Serum Institute (SI) -д үйлдвэрлэсэн Оксфорд-AstraZeneca-ийн вакцин бол Covaxin нь Bharat Biotech үйлдвэрлэж, Энэтхэгийн Анагаахын Судалгааны Зөвлөлтэй хамтран боловсруулсан вакцин юм.



Мазаалай нь энэ удаад 2020 оны 12 дугаар сарын 15-18 өдрүүдэд зохион байгуулагдсан “Экспорт Монгол 2020” Олон улсын цахим форум, үзэсгэлэнгээр зочиллоо. Та бүхэн надтай хамт байж, миний бэлдсэн мэдээллийг сонирхоорой!

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

ЭХНИЙ ЗОГСООЛ: Олон улсын цахим үзэсгэлэн

Цахим платформ дахь “Үзэсгэлэнгийн танхим”-д Монгол Улсын үндэсний 60 гаруй байгууллага, аж ахуйн нэгжийн 200 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг байршуулсан бөгөөд үзэсгэлэнд ноос, ноолуур, арьс шир, мод модон эдлэл, гоёл чимэглэл, мах, сүүн бүтээгдэхүүн, гоо сайхан, хүнс, тээвэр ложистик, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ оролцсон байна.

Цахим үзэсгэлэнд оролцогчийн үйл ажиллагаа, үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний талаарх мэдээллийг 3D, 2D павильоноос бүрэн авах боломжтой ба гадаад, дотоодын үзэсгэлэн үзэгч цахимаар шууд холбогдох боломжийг олгосноороо өндөр ач холбогдолтой болжээ. Үр дүнгээс харахад давхардсан тоогоор 24,000 гаруй хандалтаар 300 гаруй гадны болон дотоод байгууллага, аж ахуйн нэгжүүд хоорондоо холбоо тогтоож, 200 гаруй танилцуулгын материалыг татан авсан байна.

“ЭКСПОРТ МОНГОЛ 2020”

Олон улсын цахим форум, үзэсгэлэнгийн талаарх миний сэтгэгдэл

Олон улсын цахим платформоор дамжуулан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн болон бусад хүндрэл учруулахгүйгээр 100 хувь үнэ төлбөргүй зохион байгуулсан нь маш том давуу тал болсон байна.

Талаар асуудал дэвшүүлсэн хэлэлцүүлэг өрнүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх боломжит бодлого, арга хэмжээнүүдийг тодорхойлох боломжийг олгосон ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ болж өнгөрсөн байна.

Ковид-19 цар тахлын улмаас улс орны үйлдвэрлэл, худалдаа, хөрөнгө оруулалтын салбар хүндрэлтэй нөхцөл байдалтай тулгараад байгаа энэ үед төрийн болон хувийн хэвшлийн төлөөллүүд, бизнес эрхлэгч, үйлдвэрлэгч, экспортлогч, хөрөнгө оруулагчид харилцан мэдээлэл солилцох, үйлдвэрлэл, худалдаа, хөрөнгө оруулалтын тулгамдсан асуудлууд, боломжуудын

Тус цахим форум, үзэсгэлэнд 2000 гаруй төлөөлөгч оролцсоноос 300 гаруй гадаадын төлөөлөл, 1600 гаруй дотоодын төлөөлөл тус тус оролцсон байна. Мөн АНУ, Япон, Австри, ХБНГУ, Франц, ОХУ, БНХАУ, Их Британи, Сингапур, Вьетнам, Болгар, БНЭУ, Хонконг, БНСУ, Польш, Эстони, Швейцар зэрэг улс орнуудаас давхардсан тоогоор 24,000 гаруй хандалт авсан байна.



ХОЁР ДАХЬ ЗОГСООЛ: Төсөл танилцуулах B2B уулзалт

Хөрөнгө оруулагчдад төсөл танилцуулах B2B уулзалтад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Үндэсний хөгжлийн газар, Дэлхийн Банк группийн Олон улсын Санхүүгийн корпорацийн төлөөллүүд оролцжээ. Гадаадын томоохон хөрөнгө оруулагчид, хөрөнгө оруулалтын банк, санхүүгийн байгууллагуудтай цахим B2B уулзалтыг зохион байгуулж нийт 8 төслийг танилцуулсан байна.

Мөн цахим платформд Монгол Улсын *ноос ноолуур /4/, арьс шир /2/, аж үйлдвэрийн парк /4/, хүнсний үйлдвэрлэл /12/, мал аж ахуй /2/, загасны аж ахуй /2/, эрүүл мэнд /3/ болон бусад/4/* салбаруудын экспортод чиглэсэн, хөрөнгө оруулалт эрэлхийлж буй **нийт 925.7 сая ам.долларын өртөг бүхий 33 төслийн мэдээллийг байршуулсан байна.**

ДАРААГИЙН “ЭКСПОРТ МОНГОЛ 2020”

Олон улсын цахим форум, үзэсгэлэнгийн талаарх миний төсөөлөл

Олон улсын жишгийг дагаж, дижитал худалдаа, хөрөнгө оруулалтын шинэ эрин үед хамтдаа алхах зорилгоор хөрөнгө оруулалтын шинэчлэлийг хийж, хил хязгаар хаагдсан өнөө үед, хил хязгаарыг цахимаар даван Монголын үндэсний бараа бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд гаргах боломжийг нээнэ.

Тиймээс одооноос хэрэгжүүлж эхлэх хөрөнгө оруулалтын орчны талаар зөв тоотой болох, чанартай хөрөнгө оруулагчдаа ялгаж сагслах, тэдэнд илүү сайн үйлчилгээ үзүүлэх, мэдээллийг тогтмол хүргэх, мөн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчны шинэчлэлийг хийх зэрэг ажлуудыг хийснээр энэхүү арга хэмжээний цар хүрээг тэлж, Монгол Улсад хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчдын тоо илтэд нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй байна.



2021 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ЧИГ ТӨЛӨВ

- 2021 нөхцөл байдлыг дүгнэхээс өмнө суурь болох 2020 оны үр дүнг эхлээд ярилцах ёстой. Монгол улсын эдийн засаг 2020 онд 9 хувь уналттай гарах төсөөллийг Үндэсний Хөгжлийн Газраас захиалан хийсэн эрдэмтдийн судалгаа таамагласан. Харин бодит үр дүнг Үндэсний Статистикийн Газраас тооцоолж 2021 оны 5 сараас гаргахаар байна. Эдийн засгийн уналтын ихэнх хэсгийг уул уурхай, тэр дундаа нүүрсний экспортын уналт эзэлж байгаа. Засгийн газраас 2019 онд 2020 оныг төсөөлөхдөө 42 сая тонн нүүрс экспортолно гэсэн боловч жилийн эцсийн байдлаар Монгол улсын нүүрсний экспорт 28 сая тонн хүрсэн.
- ҮХГ-аас захиалан хийлгэсэн судалгаанд “CGE” загвар ашиглан тооцсон таамаглалаар эдийн засгийн уналт 13 хувь хүрэх байсан. Харин Засгийн газраас хүүхдийн мөнгө, нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлт зэрэг арга хэмжээг авсны үр дүнд эдийн засагт эерэг үр дүнг өгч, уналт саарч 9 хувьд хүрэхээр гаргасан. 2020 онд ядуурлын хувь хэмжээ хэр өөрчлөгдсөн үр дүнг гаргах судалгаа явагдаж байна.
- Дэлхийн Банк, Үндэсний Статистикийн Газраас 2018 онд хамтран гаргасан ядуурлын дүр төрх судалгаанаас харахад нийт ядуу иргэд хүн амын 28.4 хувийг эзэлж, харин 15 наснаас доош насны хүүхдүүд нийт ядуу иргэдийн 42 хувийг эзэлж байсан. Эндээс дүгнэхэд хүүхдийн мөнгө энэ Ковид-19 цар тахлын үед зорилтот бүлэгт тустай арга хэмжээ болсон гэж харагдаж байгаа юм.
- 2021 оны хамгийн чухал үйл явдал бол вакцинжуулалт юм. Монгол улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Засгийн газраас 2021 онд хэрэгжүүлэх дөрвөн зорилтыг тодорхойлохдоо нэгдүгээрт ард иргэдээ вакцинжуулах гэж оруулсан.
- Хүн амын 75 хувиас 80 хувь вакцинжуулалтад хамрагдсан тохиолдолд Ковид-19 вирус тахлын хэмжээнд тарах эрсдэлгүй болно гэж олон улсын эрүүл мэндийн байгууллагууд тодорхойлж, улмаар энэ чиглэлд үйл ажиллагаагаа идэвхжүүлээд байгаа билээ. Хэрэв вакцинжуулалтын хэмжээ энэ түвшинд хүрсэн нөхцөлд иргэдийн амьдралын хэв маяг эргэж энгийн үеийнх рүү шилжиж, ямар нэг хөл хорио, өндөржүүлсэн бэлэн байдалд орох шаардлагагүй болно. Энэ бол зөвхөн эрүүл мэндийн салбарт биш, мөн эдийн засгийн салбарт үзүүлэх нөлөөгөөр хамгийн том хүчин зүйл юм.
- Дэлхийн зах зээл дээрх ашигт малтмалын үнэ 2021 оны 2 сарын 1-р Лондонгийн Металлын Бирж дээр 7827 орчим ам.доллар байна. Гоулман Сакс компаниас 2022 онд зэсийн үнэ 10 мянган долларт хүрнэ гэсэн таамаглалыг гаргасан. Мөн манай улсын экспортын хамгийн том бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ БНХАУ болон Австрали улсын харилцааны асуудлаас үүдэн 2021 болон 2022 онд тогтвортой байх хандлага тогтлоо. Гадаад нөхцөл байдал нэн таатай байгаа үед дотооддоо нэн шаардлагатай, олон жил хүлээгдсэн томоохон төсөл хөтөлбөрийг эхлүүлж чадвал 2021 онд эдийн засаг хурдтай сэргэх боломжтой.
- 2021 оны эдийн засгийн сэргэлт хурдацтай байж болох хэдий ч, уул уурхай болон дэд бүтцийн салбарт энэхүү өсөлтийг түчээлэхээр байна. Уул уурхайн Монгол улсын төсвийн 25 хувийг бүрдүүлдэг хэдий ч, ажлын байрны 5 хувийг бий болгодог.
- Тиймээс энэ өсөлтийн цаана ажлын байр бий болгохгүй эдийн засгийн өсөлт явах эрсдэлтэй тул, бүтээмжтэй ажлын байрыг хадгалах, ажилгүйдлийг бууруулах арга хэмжээг нотолгоонд суурилж явуулах нь Засгийн газраас тавьсан дөрвөн зорилтын нэг болох учиртай.



Б.ДӨЛГӨӨН

ҮХГ-ын дэд дарга,
Хөгжлийн эдийн засагч

ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН БОЛОМЖ САЙН ЧАНАРЫН МОНГОЛ ҮХРИЙН МАХ

Энэ удаагийн дугаараар уул уурхай зэрэг олборлох салбаруудаас хэт хараат байдлаас салах, эдийн засгаа төрөлжүүлэх Монгол Улсын хамгийн боломжит, ирээдүйтэй салбаруудын нэг болох Хөдөө аж ахуйн салбарыг онцолж байна.

Хөдөө аж ахуйн салбар нь ажиллах хүчний гуравны нэг, ДНБ-ий 11 хувийг бүрдүүлдэг эдийн засгийн чухал салбар юм. Гэсэн хэдий ч энэ нь ашиглагдаагүй байгаа боломжийн маш багахан хэсэг юм.

2020 оны байдлаар 67 сая гаруй мал тоолуулсан асар их мал аж ахуйн нөөцтэй Монгол Улсын хувьд малын гаралтай мах, сүү, ноос, ноолуур, арьс шир зэрэг бараа бүтээгдэхүүнүүдийг дэлхийн зах зээлд гаргаж, эдийн засгаа өсгөх асар их боломж бий "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан Ногоон хөгжил болон Бүсчилсэн хөгжлийн зорилгын хүрээнд хөдөө аж ахуй, нэн ялангуяа, уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг эрчимжсэн мал аж ахуйтай хослуулан шинэ түвшинд хөгжүүлж, хүн амын хүнсний хэрэгцээнд махыг стратегийн гол бүтээгдэхүүнээр тодорхойлж, эрүүл органик хүнсээр хүн амыг хангах зорилгыг дэвшүүлсэн байдаг.

Иймд газар тариалан, үхрийн ферм, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарт 11 дэх жилдээ амжилттай ажиллаж, салбараа түүчээлж буй "Ханаду Razorback" ХХК-ийг өнөөдөр онцолъя.

"ХАНАДУ RAZORBACK" ХХК БОЛОН ТҮҮНИЙ ТҮҮХ

Манай компани анх 2009 онд үүсгэн байгуулагдсан, дунд болон түүнээс дээш чанартай, стандартыг хангасан мах бэлтгэлийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Хөдөө аж ахуйн чиглэлийн бизнесийг ийн эхлүүлэх болсон нь энэхүү компанийн үүсгэн байгуулагч миний биетэй холбоотой юм.

Би анх Монгол улсад 1993 онд хүмүүнлэгийн ажлаар ирж, одоогийн ферм байрлаж буй нутаг болох Булганы Хутаг-Өндөр суманд тариачдад тариа ногоо тарих заавар зөвлөгөө өгөн ажиллаж байсан юм. Өөрөө багадаа үхрийн фермд есөж, хөдөө аж ахуйтай ойр байж ирсэн нь энд гэр бүлээрээ газар тариалан эрхэлж амьдрах шийдвэр гаргахад нөлөөлсөн гэдэг. Улмаар нэгэнт хөдөө амьдарч байгаа тул өрхийн хэрэглээндээ зориулан бага тооны үхэр авч тэжээсэн нь ойр дотныхных нь байнгын хэрэглээ болоод зогсохгүй эрэлт үүсгэдэг болсон юм. Энэ явдал Ханаду Razorback компанийг байгуулах сэдлийг өгсөн.

Ханаду бол хэрэглэгч, малчид болон байгаль орчинд харилцан ашигтай модельтой бизнес юм. Хэрэглэгчийн

хувьд та өндөр чанартай махыг дотоодоосоо худалдан авч, тансаг зэрэглэлийн ресторанд л мэдэрдэг амтыг гэртээ өөрөө бэлтгээд мэдрэх боломжтой. Харин малчдын хувьд бид тогтмол худалдан авалт хийхийн сацуу салбараа аль болох хөгжүүлэх, үнэ цэнтэй байлгахад анхаардаг тул зах зээл дээрх үнээс нь дээгүүр ханшаар худалдан авахыг хичээдэг. Ингэснээр малчдадаа жилийн аль ч улиралд тогтмол орлоготой байх боломжийг бүрдүүлж өгч байгаагаас гадна урт хугацаандаа малчид фермийн аж ахуйн ач холбогдлыг ойлгодог болно, дэмжинэ, малаа нийлүүлэх дуртай болно гэж үздэг юм.



Одоогоор бид сард зургаан тонн махыг зах зээлд нийлүүлж байгаагаас борлуулалтын 80 орчим хувийг бөөний худалдаа буюу ресторан, дэлгүүрүүдэд, 20 хувийг нь жижиглэн буюу эцсийн хэрэглэгчдэд цахим платформуудаараа дамжуулан шууд хүргэж байна. 30 гаруй төрлийн зүсэлттэй мах бэлтгэгдгээс 6-7 төрөл нь стейкний мах байдаг бол бусад нь гуяны цул мах, дал, сээр, өвчүү, хавирга гэх мэт бүтээгдэхүүнүүд байдаг.

Байгаль орчны хувьд Монгол орны бэлчээрийн даац хэдийн хэтэрч, хөрсний гэмтэл, цөлжилт нэмэгдэж байгааг бүгд л харж байгаа байх. Ингэхээр бид малынхаа тоонд



ЖЕРЕМИ ТИЙССЭН

“Занаду Разорбак” ХХК-ийн
үүсгэн байгуулагч

анхаарах уу, чанарт анхаарах уу гэдгээ эргэж харах, төлөвлөх асуудал гарч ирж байгаа юм.

Одоо бол малчид эрэлтээ дагаад үхрээ таргалуулахаар хязаалан, шүдлэн болтол нь өсгөх нь элбэг. Ингэх нь нэг талаас малын эргэлт удааширч, бэлчээрт байх хугацааг ихэсгэж, даацыг нэмэгдүүлж нөгөө талаас мах нь хатуурч байдаг сул талуудтай.

Харин бид 2-3 жил бэлчээрт байсан үхрийг худалдаж аваад 3-4 сар тэжээн эргэлтэд оруулж, бэлчээрийн ачааллыг бууруулан, аль болох урт хугацаандаа газар орондоо тустай байдлаар ажлаа явуулахыг зорьдог.

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ

Ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор хөл хорионы үед тус компанид хот хоорондын тээвэрлэлттэй холбоотой нийлүүлэлтийн үйл ажиллагаа удааширах асуудал гарч байсан бөгөөд хот доторх түгээлтийн асуудал дээр ч бас QR код авахад олон хоног шаардагдсан зэрэг бэрхшээлүүд үүсэж байсан байна.

Ковидын үеийн борлуулалтын хувьд хөл хорионы улмаас 2020 оны 11-12 дугаар саруудад catering буюу хүнс үйлдвэрлэл, рестораны салбар бүрэн зогссон учраас бөөний борлуулалт багассан боловч өрхийн хэрэглээний жижиглэнгийн худалдааг онлайн захиалгаар хийж харьцангуй алдагдал багатай байсан.

2021 оны 1 дүгээр сард эдийн засаг удааширч, хувь хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурсан. Хөл хорио тавигдаж ресторанууд нээгдсэн боловч цар тахлын улмаас зай авах, үйлчлүүлэгч багатай байх зэргээс үүдэн бөөний худалдан авалт маш багасч, үйлдвэрлэл хэвийн явагдсан ч махны нөөцтэй үлдээд байна. Үйл ажиллагааны хувьд бусад аж ахуйн нэгжүүдтэй харьцуулбал харьцангуй тогтвортой явагдаж байна.

ИРЭЭДҮЙН ТӨЛӨВЛӨГӨӨ / ЗОРИЛГУУД

Бид одоогоор нийт зорилтот хэрэглэгчийнхээ 10 хувийг нь л бүтээгдэхүүнээрээ хангаж чадаж байна гэж тооцоолж байгаа. Энэ

хүчин чадлаа нэмэгдүүлэхийн тулд фермийн үйл ажиллагаагаа жигдрүүлэх, үхэрнүүдийнхээ хооллолт, өгч буй шим тэжээлийг илүү оновчтой, хүртээмжтэй болгох, судлах, хөрөнгө санхүү босгож бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжөө нэмэгдүүлэх, логистикоо сайжруулах зэрэг олон шат дараатай ажлуудыг хийх шаардлагатай болно.

Гэхдээ анх байгуулагдсан үеэ бодвол 600 үхэр нэг дор хүлээн авах чадалтай, бас стандартын цехтэй болсондоо бид сэтгэл хангалуун байдаг. Энэ эрчээрээ тогтмол хурдтайгаар тасралтгүй урагшлахыг хичээж байна. Ойрын таван жилдээ дотоодын зах зээлдээ илүү анхаарах төлөвлөгөөтэй.

Монгол Улсад хөгжиж буй боломжит салбаруудаас мах үйлдвэрлэлийн салбар хөгжих онцгой боломжтой юм. Мах үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулагч Та бэлэн газартай, мал аж ахуй эрхлэх туршлагатай ажилтнуудтай, мал сүргийн асар их нөөцтэй эрүүл, органик Монгол брэндийг үйлдвэрлэж, дэлхийн тавцанд хамтдаа гарах боломж таны гарт байна.


xanadu
Razorback Ltd.



XanaduRAZORBACK Ltd.



+976 8689 6869



www.xanadurazorback.com


ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЭРЭЛХИЙЛЖ БУЙ МОНГОЛЫН ГАРААНЫ БИЗНЕС

hello
baby



“HELLO BABY”

ЖИРЭМСЭН ЭЭЖИЙН ХӨТӨЧ
АППЛИКЕЙШН



HELLO BABY - ЖИРЭМСЭН ЭЭЖИЙН ЦОГЦ ХӨТӨЧ

Монгол бүсгүйчүүдийн хөгжүүлж буй Hello Baby хэмээх “Жирэмсэн ээжийн хөтөч апп”-ыг онцлон танилцуулж байна.

Тус апп-ыг үүсгэн байгуулагч бүсгүйчүүд жирэмсэн үе болон хүүхэд өсгөж бойжуулахтай холбоотой өөрт тулгарсан асуудлаас санаа авч, эмэгтэйчүүд, хүүхдийн эрүүл мэнд, гэр бүлд чиглэсэн бүтээгдэхүүний хэрэгцээ байгааг олж харсан нь уг апп-ыг бүтээх сэдэл болсон байна.

“Бяцхан үрээ хэвлийдээ тээх гайхамшигт аяллын турш таны гараас хөтлөн, туслан чиглүүлэх болно” гэх уриатай Hello Baby апп-ны гол онцлог бол бүх зөвлөгөө, мэдээлэл нь монгол бүсгүйчүүдийн амьдралын хэв маягт уялдсан юм.



Hello
Baby

- Энэ төрлийн Монголын хамгийн анхны аппликейшн
- 3 ээж хамтран бүтээсэн
- 40,000 гаруй удаа татагдсан

- Зөвхөн танд зориулсан жирэмсний үетэй уялдсан зөвлөгөө, мэдээлэл
- Жирэмсний няналт, үзлэгт орох алхмууд
- Эмчдээ үзүүлэх хуваарь
- Хийх ажлыг сануулах сэрүүлэг
- Жирэмсэн ээжүүдэд түгээмэл илэрдэг шинж тэмдгүүдийн талаарх мэдээлэл
- Хувийн ажлаа төлөвлөх боломжтой талбар + тэмдэглэл
- Жирэмсний үеийн бүх үзлэг, шинжилгээний тайлбар


f hellobabymama

+976 9910 0516

http://www.hellobaby.mn/

Z admin.zochil.shop

**Вэбээр онлайн
худалдаагаа
удирдах
боломжтой**



ОНЛАЙН ХУДАЛДААГ ХӨГЖҮҮЛЭГЧ “ZOCHIL” ПЛАТФОРМ

Монгол Улсад өнөөдөр онлайн худалдааны бизнес маш эрчимтэй хөгжиж, хувь хүн, аж ахуйн нэгжүүд дижитал шилжилтийн эхлүүлж байна. Гэвч онлайн худалдааны бизнесийг хөгжүүлэхэд вебсайт, аппликейшн гэх платформуудыг ашиглах шаардлага үүсдэг.

Тиймээс одоогийн зах зээлийн ханшаар бодоход 20 орчим сая төгрөгөөр бүтдэг вебсайт, аппликейшн нь жижиг, дунд үйлдвэрлэгч, хувираа бизнес эрхлэгч

нарт асуудал болж байгааг олж харан 2019 онд энэхүү бизнесийг эхлүүлсэн. Монгол залуучуудын хөгжүүлсэн zochil.shop платформоор та 3 мин дотор сард ердөө 55,000 төлөөд өөрийн онлайн худалдаагаа явуулах бүрэн боломжтой юм.

“Zochil” платформын үйлчилгээг авснаар хэрэглэгчид өөрийн онлайн дэлгүүрийг гар утаснаасаа, орон зайг үл хамааран хаанаас ч нээж, үйл ажиллагаагаа автоматжуулан ашиг орлогоо нэмэх боломжтой.

Тэд гар утасны хувилбараас гадна хэрэглэгчдэдээ зориулан admin.zochil.shop онлайн худалдаа удирдлагын вебсайтыг хөгжүүлсэн тул давхар веб хуудсаар дамжуулан бизнесээ удирдах, фэйсбүүк чатаар бараа бүтээгдэхүүнээ борлуулах, “Zochil” чатбот үйлчилгээг нэмэлтээр ашиглах боломжтой.



- Монгол залуучууд бүтээсэн
- 300 гаруй харицлагчтай



Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050", Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт төрийн үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах ажлыг тусгасан. Энэ дагуу Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-г 2020 оны аравдугаар сарын 2-нд албан ёсоор олон нийтэд танилцууллаа. E-Mongolia системд өнөөдрийн байдлаар төрийн 23 байгууллагын 181 үйлчилгээ орсон бөгөөд 2021 онд 600 орчим төрийн үйлчилгээг нэгтгэхээр ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, иргэн та www.e-mongolia.mn веб портал болон e-mongolia гар утасны аппликейшнээс өөрт хэрэгтэй төрийн үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран цахимаар авах боломж бүрдэж байна.

- Төр хувийн хэвшилтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, ашиглалтын нэмэгдүүлэх зорилгоор дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн.

- Үүрэн холбооны Мобиком, Скайтел, Юнител, Жи-Мобайл компаниуд E-Mongolia-н хэрэглээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэд E-Mongolia мобайл аппликейшн болон портал системийг ашиглах үед дата үйлчилгээний төлбөрийг тэглэх зохицуулалтыг хийсэн. E-Mongolia-д дуу яриаг хөрвүүлдэг Chimege систем нэвтэрсэн тул харааны бэрхшээлтэй иргэд www.e-mongolia.mn сайтаар зочилж, үйлчилгээний зааврыг сонсож танилцах боломжтой болсон бөгөөд цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэд E-Mongolia дамжуулан төрийн үйлчилгээг саадгүй авдаг байх нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

- Дараагийн нэг онцлох алхам бол E-Mongolia платформд иргэдийг аль болох олон боломжоор нэвтрүүлэх зорилгоор арилжааны банкуудтай хамтарч иргэд цахим банкныхаа нэвтрэх эрхийг ашиглан E-Mongolia системд нэвтрэх боломжийг бий болголоо.

- Монгол Шуудан компанитай хамтран хэрэгжүүлсэн нэг ажил бол иргэд төрийн үйлчилгээг цахимаар авч, шуудангаар гэртээ хүргүүлэх боломжтой болсон явдал юм. Өөрөөр хэлбэл иргэний үнэмлэх, гадаад паспорт зэрэг бичиг баримтаа захиалаад гэрийн хаягаараа хүргүүлэн авах боломжтой болсон.

- Харилцагчийн үйлчилгээг сайжруулах зорилгоор Chatbot системийг Chatbot компанитай хамтран амжилттай нэвтрүүлээд байна. Үр дүнд нь иргэд цагийн бүсээс үл хамаарч тусламж дэмжлэг авах боломж бүрдэнэ. Гадаад улсад ажиллаж, амьдарч буй иргэд Chatbot үйлчилгээг ашигласнаар тухайн орныхоо цагийн бүсээс үл хамаарч төрийн үйлчилгээтэй холбоотой мэдээлэл chatbot -с авч

болно гэсэн үг юм.

- Цаашид иргэд төрийн үйлчилгээ авахын тулд өөрсдөө ханддаг бус төрийн үйлчилгээ тан дээр очдог болохын төлөө ажиллаж байна. Тухайлбал, таны гадаад паспорт, иргэний болон жолооны үнэмлэхийн хугацаа дуусахаас 1-6 сарын өмнө баримт бичгээ сунгах эсэх талаар мэдэгдэл танд ирнэ. Мэдэгдэл дээр тийм гэсэн товчийг дарахад л таны бичиг баримтын сунгалт хийгддэг байх хөгжүүлэлтийг хийхээр зорин ажиллаж байна.

- Төрийн үйлчилгээг цахимаар авах эрэлт хэрэгцээ өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь өнгөрсөн хугацааны статистик үр дүнгээс харагдаж байна. Сүүлийн хоёр сарын статистикийн мэдээллээс харахад өдөрт дунджаар 4000-6000 иргэн төрийн үйлчилгээг E-Mongolia системээс авч байна.

- 2021 оны 1 сарын 25-ны өдрийн байдлаар нийт 511,557 иргэн үйлчилгээ авах хүсэлтээ E-Mongolia нэгдсэн системээр илгээж давхардсан тоогоор 398,167 удаа төрийн үйлчилгээг амжилттай аваад байна.

- Цахим шилжилттэй холбоотойгоор иргэд төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, хаана байгаа газраасаа, цахимаар түргэн шуурхай авах боломж бий болохын зэрэгцээ зэрэгцээ төр талдаа томоохон зардлын хэмнэлт гарч байгаа. Тухайлбал орон тооны давхцалыг багасгаж, цаасны хэрэглээг бууруулах, шатахууны хэрэглээ буурах зэргээс тооцож үзвэл жилд дунджаар улсын төсвөөс жилдээ 24 тэрбум 201 сая 860 мянга 884 төгрөг хэмнэнэ гэсэн судалгаа гарчээ. Тодруулбал, бичиг хэргийн зардал 492 сая төгрөг, шуудангийн зардал 2463 сая төгрөг, шатахууны зардал 612 сая төгрөг, хөдөлмөрийн хөлс болох 20 тэрбум 632 сая зэрэг зардлууд хэмнэгдэх юм.

Мөн төрийн цахим шилжилтийг хурдасгах, цахим засаглалын хууль эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор багц хуулийн төсөл боловсруулагдаж байна. Тухайлбал, Төрийн цахим харилцааны тухай хуулийн төсөл, Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн төсөл, Өгөгдөл хамгаалах тухай хуулийн төсөл Хууль зүй, дотоод хэргийн яам болон Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар хамтран боловсруулж байна.



С.ГАНТОГОО

Бодлого, төлөвлөлт стратегийн газрын дарга
Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар

ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН ХӨРӨНӨ ОРУУЛАЛТ

МОНГОЛЫН ФИНТЕКИЙН САЛБАР

Финтек буюу Financial Technology / санхүүгийн технологи / гэж юу вэ?

Санхүүгийн технологи (Финтек) нь онлайн банк, гар утасны төлбөрийн аппликейшн, криптовалют зэрэг програм хангамжаар дамжуулан санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг аливаа технологийг тодорхойлоход хэрэглэгддэг нэр томъёо юм. Товчхондоо, финтек гэдэг нь санхүү болон технологийн салбарын огтлолцлыг хэлнэ. Финтек нь олон төрлийн технологийг хамарсан өргөн цар хүрээтэй ойлголт боловч үүний үндсэн зорилго нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашигласнаар шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна одоо байгаа үйлчилгээг илүү амар, хялбар, аюулгүй, түргэн, шуурхай болгох замаар гүйлгээний шимтгэл, төлбөр, хураамжийн зардлыг бууруулах зорилготой юм. Өөрөөр хэлбэл, та ямар нэгэн санхүүгийн үйлчилгээг банканд очерлон авах шаардлагагүй болжээ.

Монгол дахь Финтекийн салбарын хөгжил

Монгол Улсад финтекийн тухай ойлголт нь 2014 оноос хойш үүссэн бөгөөд уг салбарыг хөгжүүлэхэд ЛендМН, Ард Кредит, Most Money, ZeelMN, Mobi Finance, Hi-pay зэрэг финтекийн компаниуд нэн чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Монгол Улсад 3.32 сая гаруй ухаалаг гар утас хэрэглэгч байдаг бөгөөд эдгээр хэрэглэгчдийн 59% нь өргөн зурвасын (3G-4G) интернетийн сүлжээнд холбогддог. (Эх сурвалж: Харилцаа холбооны зохицуулах хороо) Гар утасны хэрэглээ маш өндөр учраас иргэд онлайн банк, финтек програмуудыг ашиглан өөрсдийн банкны данстайгаа холбон санхүүгийн үйлчилгээ болон шуурхай зээл зэргийг авах нь өдрөөс өдөрт нэмэгдэж байна. Энэ нь финтекийн уламжлалт банк, санхүүгийн үйлчилгээнээс ялгарах давуу тал болох үүссэн санхүүгийн үйлчилгээгээ алсын зайнаас өөрийгөө таниулж баталгаажуулан цаг хугацаа, мөнгө санхүүгээ хэмнэх боломжийг олгож байгаатай холбоотой билээ. Жишээлбэл, финтекийн гарааны "ЛендМН ББСБ" ХК нь 93,081 харилцагчид 835,000 гаруй удаа зээл олгосон бөгөөд 93,081 харилцагчийн зээл авахад зарцуулах шууд бус зардал буюу 1,5 тэрбум төгрөгийг хэмнэсэн ба зээл авахад зарцуулах байсан 279,000 цаг буюу 31,8 жилийг хэмнэсэн гэсэн судалгааг гаргажээ. (Эх сурвалж: "ЛендМН ББСБ" ХК, lend.mn)

Монгол дахь Финтектэй холбоотой хуулийн зохицуулалт

Монгол Улсад 2018 оноос хойш хэрэгжиж буй Үндэсний төлбөрийн системийн тухай хууль нь үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахаас гадна үндэсний төлбөрийн системд банкнаас бусад этгээд оролцох боломжийг нээж өгснөөр финтек компаниудыг төлбөрийн системд оролцох гарцыг нээн өгчээ. Монгол банкнаас Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан финтек компаниудад төлбөрийн үйлчилгээний зөвшөөрлийн гэрчилгээг олгодог. Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд зааснаар дижитал мөнгө буюу цахим мөнгө гэдэг нь Монгол банкнаас баталсан Монгол Улсын бэлэн бус төлбөрийн хэрэгсэл бөгөөд төгрөгтэй тэнцэх үнэ цэн бүхий дүнтэй байна. Дижитал мөнгө нь дараах шинж чанаруудтай: цахим хэлбэрээр хадгалагдах, бэлэн мөнгөөр баталгаажсан, гуравдагч этгээд хүлээн зөвшөөрсөн, бэлэн мөнгөөр чөлөөтэй хөрвөх чадвартай, зээлийн эх үүсвэр болохгүй, цахим мөнгөний нэг нэгж нь 1 төгрөг (Монгол үндэсний мөнгөн тэмдэгтийн хамгийн жижиг нэгж)-тэй тэнцүү байна.

МОНГОЛ ДАХЬ АМЖИЛТТАЙ ФИНТЕК КОМПАНИЙН ТҮҮХҮҮД



"Ард Кредит ББСБ" ХК нь өөрсдийн мобайл аппликейшнаар дамжуулан санхүүгийн олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлчлүүлэгчид санал болгодог. Тухайлбал, Ард Апп нь цахим худалдаа, даатгал, хадгаламж, үнэт цаас, онлайн зээл, мөнгөн шилжүүлгийн үйлчилгээг хиймэл оюун ухаан болон блокчэйн технологид суурилсан системийн тусламжтайгаар шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж байна. 2020 онд Ард Кредит нь компанийн 25% буюу 70 сая ширхэг хувьцааг олон нийтэд санал болгосон бөгөөд стратегийн хөрөнгө оруулагчдаас 2.5 тэрбум төгрөгийг, 1763 иргэн, аж ахуйн нэгж анхдагч зах зээлд нийт 7.3 тэрбум төгрөгийн захиалга хийж, тооцоолсон хэмжээнээс 299 хувиар давж биелүүлжээ.



ЛендМН ББСБ” ХК нь хиймэл оюун ухаанд суурилсан зээлийн үнэлгээний мобайл аппликейшнийг ашиглан хэрэглэгчид барьцаа хөрөнгөгүйгээр түргэн, шуурхай зээл авах боломжийг олгосон Монголын анхны “FinTech” санхүүгийн үйлчилгээний компани юм. “ЛэндМН ББСБ” ХК-ийг Олон Улсын “AsiaMoney” сэтгүүлээс 2019 оны “Монгол Улсын шилдэг цахим үйлчилгээ үзүүлэгч компани” мөн “Global Banking & Finance Review” сэтгүүлээс 2020 оны “Шилдэг финтек компани”-аар шалгаруулжээ.

Мөн тус компани нь 2020 онд хөрөнгийн зах зээлд нээлттэй арилжаалагдах “ЛЭНДМН БОНД”-ыг гаргах зөвшөөрлөө Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан бөгөөд энэхүү бонд нь Монголын хөрөнгийн зах зээл дээр финтек компанийн гаргаж буй анхны нээлттэй бонд болсон билээ. “Анд глобал” компани нь Анд Системс ХХК болон ЛэндМН ББСБ ХК-ийн толгой компани бөгөөд өөрсдийн бүтээсэн санхүүгийн технологийн (финтек) шийдлүүдээ олон улсад нэвтрүүлэхээр худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Япон улсын “Марубени” корпорацитай стратегийн хамтын ажиллагааг эхлүүлж хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан.



“Моби Финанс ББСБ” ХХК нь онлайн зээлийн “Мессеж зээл” үйлчилгээг зах зээлд анх нэвтрүүлж, амжилттай хэрэгжүүлж байна. Мөнгөний үйлчилгээ нь мөнгөн шилжүүлэг хийж, бичил зээл авч төлбөр тооцоо, гүйлгээг хормын дотор гүйцэтгэх бөгөөд онлайн дэлгүүр, төмөр зам, кино үзвэрийн тасалбар, хоол, хүнс хүргэлт, тоглоом цэнэглэлт, купон, урамшуулал зэрэг маш олон үйлчилгээг нэг дор агуулснаараа бусад санхүүгийн үйлчилгээнээс ялгардаг.



SENDLY аппликэйшн нь гадаадад буй Монголчуудад зориулсан албан ёсны тусгай зөвшөөрөлтэй анхны олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ юм. “Гялс Кредит ББСБ” ХХК нь АНУ-ын 31 муж улсад мөнгө шилжүүлэх тусгай зөвшөөрөлтэй Golden Money Transfer, Prabhu Money Transfer, Moneytun компаниудтай хамтын ажиллагаагаа эхлүүлж, онлайн мөнгөн гуйвуулгын SENDLY аппликэйшнийг нэвтрүүлжээ.



High Payment Solutions ХХК нь Монгол улсын хэмжээнд төлбөрийн экосистем байгуулах зорилгоор 2018 онд байгуулагдсан. Hi-Pay нь аль ч банкны ямар ч төрлийн картыг холбон шимтгэлгүйгээр гүйлгээ хийх боломж бүхий цахим төлбөрийн цогц шийдэл болсон дижитал хэтэвч юм.



Монголын Финтекийн холбоо нь Засгийн газрын дэмжлэгтэйгээр финтек үйлчилгээний олгож буй шилдэг боломж, давуу талуудыг зах зээлд нэвтрүүлэх, үүнтэй холбоотой хууль, дүрэм журамд өөрсдийн хувь нэмрийг оруулах, оролцогч талуудыг нэгтгэх, холбох замаар финтек компаниудад тулгарч буй асуудлуудыг шийдэхээр ажилладаг. Одоогоор тус холбоо нь Төв банк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран шинээр үүсэж буй болон зах зээлд үйл ажиллагаагаа явуулж буй финтек байгууллагуудыг дэмжсэн сэндбокс зохицуулалтын орчинг бий болгож, зах зээлийн өнөөгийн хэрэгцээнд нийцсэн шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүнийг бий болгохоор зорин ажиллаж байгааг мэдэгджээ.

Холбооноос “Mongolian Fintech Association” Facebook хуудас, contact@mongoliafintech.org



Э.БАТЧИМЭГ

Хөрөнгө оруулалтын бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн
мэргэжилтэн

2020 ОНЫГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХУВЬД ЭРГЭН ХАРАХАД...



“Төр, засаг баялаг бүтээгчдийг, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих, аль болох түншлэх чиглэлийг барьж ажиллана. Энэ үүднээс бид бизнесийн тогтвортой орчинг бүрдүүлсэн бодлогын томоохон шинэчлэл рүү алхаж байна.”

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

“Манай улсад иргэний эрх зүй, бизнесийн эрх зүй чиглэлээр хууль зүйн зөвлөх үйлчилгээ харьцангуй сайн хөгжиж өрсөлдөөн ихтэй болж байгаа. 2012 онд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсанаар хуульчид нөхөрлөл хэлбэрээр зохион байгуулагдаж хамтран ажиллах боломж бүрдсэн.”

”

Б.СОЛОНГО

ЗГХЭГЫН ДЭД ДАРГА



“АмЧам Монгол нь Ковид-19 цар тахал Монгол улсад дэгдэхээс сэргийлэн шаргуу ажиллаж буй нийт эмч, эмнэлгийн ажилтнуудад маш их талархаж буйгаа илэрхийлье. Монгол Улс энэхүү цар тахлаас урьдчилан сэргийлэх талаараа дэлхийн олон орны тэргүүн эгнээнд явж байна.”

”

ЖЭЙ ЛИОТТА


АМЧАМ МОНГОЛЫН ТУЗ-ИЙН ДАРГА

“Эдийн засгийн өнөөдрийн хүндрэлийг төр, хувийн хэвшил хамтарч байж л даван туулна. Тиймээс итгэлцэл, ойлголцол чухал. Цаашид гадаад худалдааг дэмжих, хөрөнгө оруулалт татах, уул уурхайн бус экспортыг төрөлжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг илүү сайжруулах, Монголын бараа бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлан таниулах нь бидний ойрын зорилт.”

”

О.АМАРТҮВШИН

МУХАУТ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ



“Хөдөлмөрийн зах зээл, хүний нөөцийн салбарыг 180 градус эргүүлэхийн тулд бид олуулаа болж, хамтран ажиллах хэрэгтэй.”

”

З.УЯНГА

“НИТОТЕК” КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

“Монголдоо олон улсын стандарт бүхий өндөр цалин авч ажиллах боломжийг ИТ салбар өгч байна.”

”

А.АЗБАЯР

SPECIALIZED CAREER CONSULTING /SCC/ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ





МОНГОЛ СОЁЛООС ТАНД...

НОХОЙТОЙ ЧАРГАНЫ АЯЛАЛ

Монгол Улсыг өвлийн улиралтай байж өвлийн спорт хөгжөөгүй хэмээн шүүмжлэх гадна дотны улс цөөнгүй. Гэхдээ чадах чинээгээрээ тодорхой хүрээлээс эхлэн бага багаар хөгжиж буйг онцолж, нохойтой чарганы аялал хэмээх өвлийн сонирхолтой аяллыг танилцуулъя. Нохойтой чарганы аялал нь дэлхийн өнцөг булан бүрт түгэн дэлгэрсэн байдаг. Цас, мөсөөр чаргыг чирэхэд нохой ашиглаж эхэлсэн нь жилийн ихэнх хугацаанд өвөл үргэлжилдэг Аляска, Сибирээс эхэлжээ. Үүний тулд тусгай үүлдрийн нохдыг өсгөн хүмүүжүүлдэг байсан байна. Жил бүр Шведийн аяллын хувцас үйлдвэрлэдэг "Fjallraven" компани нохойтой чарганы уралдааныг зарлаж, цахим ертөнцөөр санал авч тэргүүлсэн оролцогчид хойд туйл руу нохойтой чарганы аялалд гарч, адал явдлыг эрэлхийлдэг байна. Энэ спорт нь манай улсын ахуйн амьдралтай ойр тул Монгол хүн тэсвэр, хатуужлаа харуулахаар оролцдог. Үүнд нүүдэлчдийн ахуй, соёлыг дэлхийд таниулан сурталчлах зорилгоор манай улсын хэд хэдэн тамирчид, тэр дундаа 3 эмэгтэй жил дараалан оролцож, санал асуулгаараа дээгүүр жагссан юм. Дэлхий дахинд хэдийнээ танигдсан алсын Аляскад болдог энэхүү аялал манай улсад ч сүүлийн жилүүдэд нэлээд дэлгэрээд байгаа билээ. Битүү цас мөсөн дунд ухаалаг, чадварлаг Аляскийн Хаски үүлдрийн

нохой хөлөглөн аялалд гарч, голын эрэг дагасан цастай уулын сүрлэг үзэмж, сэнгэнэсэн агаар, уур савссан голын манан зэрэг сэтгэлд тод дурсамж үлдээх гайхалтай байгалийг үзэж аялах нь үнэхээр ч сонирхолтой юм. Тиймээс нэг өдрийг цэвэр агаарт, хөгжилтэй, зугаатай өнгөрүүлэх хүсэлтэй хэн бүхэнд хандаж, "Grand Mongolian adventures" компанийн "Тэрэлж" аялал жуулчлалын бүсэд зохион байгуулдаг нохойтой чарганы аяллын талаарх мэдээллийг сонирхуулж байна. Тухайн байгууллага нь нийт 80 нохойгоор нэгэн зэрэг 8-12 чаргаар 40-220 хүнийг нэг удаагийн өдрийн аялалд давтамжтайгаар аялуулах боломжтой бөгөөд нэг чарганд 6-8 нохой байна.

Аяллын эхэнд нохойтой чарганд явдаг өхөөрдөм хөөрхөн хаскинуудтай уулзаж танилцана. Үүний дараагаар аяллыг удирдан чиглүүлэх мэргэжлийн хөтөч нохойтой чаргаар аялах зөвлөгөө өгснөөр нохойтой чаргаар өвлийн сэнгэнэсэн агаараар салхи татуулах давхих болно. Энэхүү нохойн чарганы аялаар та жинхэнэ өвлийн хамгийн гоё газар нутгийг үзэх болно. Үүнээс гадна нохойтой чарганы аяллын дараагаар Мөсөн агуйгаар зочлох, байгууллагын бааз дээр байрлах дулаан ресторанд халуун хоол цайгаар зочлуулах, цасаар хөгжөөнт тоглоом тоглож наадан амралтын өдрөө сайхан өнгөрүүлэх боломжтой.

Маршрут: Улаанбаатар хотоос 35 км, автобусаар өглөө 9 цагт яваад орой 6 цагт буцаж хотод ирнэ. Аялал зохион байгуулж байгаа газар ирэх зам халтиргаа гулгаа аюул байхгүй тул жижиг ямар ч машинтай очоод аялах боломжтой.



Аялалд гарахдаа хувь хүн аялахад тохиромжтой, дулаан хувцас өмсөж, өөрийн бэлтгэлээ маш сайн базаасан байх хэрэгтэй. Мөн нэмж зөвлөхөд, ганц нэгээрээ аялалд явахад ганцаардана гэж санаа зовох хэрэггүй. Тус аялалд хамрагдсан хүмүүсээс маш олон хүн найз нөхөдтэй болсон байдаг. Иймээс юунд ч санаа зоволгүй аялалдаа оролцоод үзээрэй.

НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ЗОРИУЛСАН “INVEST IN MONGOLIA” НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан “Invest in Mongolia” нэг цэгийн үйлчилгээний төв нь албан ёсоор 2019 оны 2 дугаар сард нээлтээ хийсэн бөгөөд энэ хугацаанд Улсын Бүртгэлийн Ерөнхий газар, Татварын Ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Нийгмийн даатгалын Ерөнхий газруудтай хамтран нийт 60 гаруй төрлийн 54,000 гаруй үйлчилгээг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад үзүүлээд байна.

Ковид 19 цар тахлын хүнд хэцүү үед ч бид үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлж, хөрөнгө оруулагчдад биеэр, утсаар, цахимаар үйлчилгээ, зөвлөгөө, мэдээллийг хүргэсээр байна.

Нэг цэгийн үйлчилгээний төвөөс

дараах төрийн үйлчилгээ, зөвлөгөө, мэдээллийг гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлж байна:

- Хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчны зөвлөгөө, мэдээлэл; Хөрөнгө оруулалтын татварын болон татварын бус дэмжлэг, баталгааны зөвлөгөө, мэдээлэл;
- Төрийн үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө оруулагчдад тулгарсан гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх цахим системийг ажиллуулах;
- Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн бүртгэл, оноосон нэрийн баталгаажуулалт нэмэлт, өөрчлөлт, лавлагаа, тодорхойлолт, хөрөнгө оруулагчийн карт, бусад түүнтэй холбоотой дагалдах үйлчилгээ, зөвлөгөө, мэдээлэл;

- Татварын зөвлөгөө мэдээлэл, татвар төлөгчийн бүртгэл, тоон гарын үсэг олгох, лавлагаа, тодорхойлолт гаргаж өгөх, тайлан хүлээж авах, гадаад хөрөнгө оруулалттай компаниуд, хөрөнгө оруулагчдын авто тээврийн хэрэгслийн татвар хураах;
- Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл олгох, түр ирэгчийн бүртгэл, хасалт хийх болон оршин суух зөвшөөрөл олгох, сунгалт хийх, түүнтэй холбоотой зөвлөгөө, мэдээлэл;
- Нийгмийн даатгалын бүртгэл тайлан хүлээж авах, лавлагаа, тодорхойлолт гаргах, зөвлөгөө мэдээлэл өгөх зэрэг үйлчилгээнүүд багтаж байна.



Засгийн газрын 2-р байр хойд талд, Нэгдсэн Үндэстний Гудамж, Улаанбаатар 15160

Ажлын өдрүүдэд өглөө 08:30- 14:00

976-77001717,9906-9374, 9928-8808

<https://invest-assist.gov.mn>

contact@investmongolia.gov.mn



ONE STOP SERVICE CENTER